

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛЬ



# 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН

АНГЛИ ХЭЛНИЙ БАГШ СҮХБААТАР ОВОГТОЙ МЯГМАРСҮРЭН

2019 ОН

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛИЙН  
АНГЛИ ХЭЛНИЙ БАГШ С.МЯГМАРСҮРЭНГИЙН  
2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**I. Төлөвшил**

1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал  
Сургуулиас зохиогдсон олон нийтийн ажилд идэвхитэй оролцдог. Үүнд
  - Цэнэглэх цаг” бүрийг алгасалгүй сууж оюунаа хөгжүүлдэг /Энэ хичээлийн жилд 7 цэнэглэх цагт суусан/
  - Сар бүрийн жижүүр багшийн үүргээ хариуцлагатай гүйцэтгэдэг /Энэ хичээлийн жилд сар бүр жижүүр багшийн үүргийг гүйцэтгэж жижүүр багшийн үнэлгээний хуудсаа хариуцлагатай жижүүрээсээ авч дүгнүүлсэн. Нийт 8 удаа жижүүр багшийн үүргийг гүйцэтгэн Жижүүр багшийн үнэлгээний хуудсыг авч дүгнүүллээ/
  - “Эцэг эхийн нээлттэй хаалга” үйл ажиллагаанд оролцож эцэг эхчүүдэд санал зөвлөмж өгч ярилцав
  - Англи хэлний Олон улсын эсээ бичлэгийн уралдааны зохион байгуулалтад оролцов
  - Сурагчдын дунд “Хүүхдийн дуу хоолой ” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав
  - Хэлний наадамд 5в ангийг бэлтгэн оролцуулсан
  - Дүүргийн гадаад хэлний багш нарын хэлэлцүүлэгт илтгэл хэлэлцүүлсэн
  - Бай.Алтанцэцэг багшийн Монгол бичгийн сургалтад хамрагдсан
  - Судалгаат хичээлүүдэд оролцсон
  - Бусад хичээлийн мэдлэг чадварын сорил, анги дэвших шалгалтыг ангиудаас авч протокол хөтөлсөн
  - БМДИ-ийн болон сургуулиас зохион байгуулсан сургалт семинарт сууж мэргэжлээ дээшлүүлдэг
  - Багш нарын хурал
  - Moodle шалгалтын системд суралцаж 8-р ангийн 3, 4-р улирлын нэгж хөтөлбөрийг боловсруулсан
  - 3, 4-р улирлын цахим хичээлүүдийг бэлтгэх
  - Анги удирдах урлаг анхдугаар зөвлөгөөнд оролцов
  - Бүх нийтийн мод тарих өдөрт оролцсон
  - Дүүрэг нийслэлийн гадаад хэлний багш нарын илтгэлийн уралдаанд амжилттай оролцсон
2. Дэгийн хэрэгжилт, дадал хэвшил суусан байдал
  - Сурагчдад хичээлийн дэг, завсарлагааны дэгүүдийг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулан ажилладаг
  - Хичээл ордог ангиуддаа дэгийн хэрэгжилтийг биелүүлэхийн тулд өөрийн хичээл дээр бас сануулах хуудас /шар, ногоон, улаан / өгч тухайн сурагчид анхааран ажиллаж байна
  - Шинэ үгийг хичээл болгоны эхний 5 минутад шалгаж бие биенийг нь шалгуулан, дүгнүүлж хэвшсэн
  - Сурагчид гэрийн даалгавраа шалгаж хэвшсэн
  - Ангийн ариун цэвэрт анхааран хичээлийн эхэнд дор бүрнээ хогоо авч хичээлээ эхэлдэг
  - Кабинет хоорондоо явахдаа баруун гараа даган жагсаж хичээлдээ явдаг
3. Бусадтай харилцах зан чанар

- /Туршлагатай, ахмад багш нараасаа суралцан тэднийхээ хичээлд сууж тэмдэглэл хөтлөн туршлага судалдаг. Харин үе тэнгийн залуу багш нартайгаа сурсан мэдсэнээ хуваалцдаг/
- 4. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал хэвшил зан чанарын байдал
  - Хичээл ордог ангиуддаа дэгийн хэрэгжилтийг биелүүлэхийн тулд өөрийн хичээл дээр бас сануулах хуудас /шар, ногоон, улаан / өгч тухайн сурагчид анхааран ажиллаж байна
- 5. Жижүүр багшийн үнэлгээ
  - Жижүүр багшийн үүргийг энэ хичээлийн жилд 8 удаа хийж гүйцэтгэж дүгнүүлэн үнэлгээний хуудас авсан
- 6. Хэдэн судалгаа хийсэн, ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал
  - Жижүүр багшийн үүргийг энэ хичээлийн жилд 8 удаа хийж гүйцэтгэж дүгнүүлэн үнэлгээний хуудас авсан
  - Жижүүр багш хийхдээ эхний сард 25 оноо авч байсан бол сүүлийн бөгөөд 11-5 сард алдаа дутагдлаа засан сайжруулж 30 оноог авч чадсан
- 7. Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн
  - Эцэг эхийн нээлттэй хаалга үйл ажиллагаанд анхаарах шаардлагатай сурагчдын жагсаалт гарган эцэг эхтэй нь уулзаж ярилцсанаар тухайн сурагчдад тодорхой хэмжээний өөрчлөлт гарсан
  - Эцэг эхийн нээлттэй хаалганы үйл ажиллагаанд ирж амжаагүй эцэг эхийг утсаар холбогдон уулзсан

## II. Мэдлэг чадвар ахиц, амжилт

### 1. Гарааны болон Оношлох үнэлгээ

№	Судлагдхууны нэр	Бүлэг	тоо	VIII	VII	VI	V	IV	III	II	I
1	5-Р АНГИ	5В	30		4	8	5	5			
2	7-Р АНГИ	7А	25			5	2	10	4	4	
3		7Б	29			4	10	5	5	5	
4		7Г	28			3	10	6	5	5	
5		7Д	29			4	5	5	10	5	
6		7Е	30			2	10	10	5	3	
8		8Д	30			3	10	10	6	2	
	НИЙТ	7	201		4	27	52	31	35	2	4

2. Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /MOODLE/

Анги	I	II	III	IV
8д	2	2	3	3
7а	2	2	3	3
7б	2	2	3	3
7г	2	2	3	3
7д	2	2	3	3
7е	2	2	3	3
5в	5	5	4	4

3.Стандарт хэрэгжилт

№	Судлагдхууны нэр	Бүлэг	НЭГЖ ХИЧЭЭЛ		ЭЭЛЖИТ	
			боловсруулвал зохиx	боловсруулж баталгаажуулсан	боловсруулвал зохиx	Боловсруулж баталгаажуулсан
1	5-Р АНГИ	5В	18	18	165	165
2	7-Р АНГИ	7А	10	10	102	102
3		7Б	10	10	102	102
4		7Г	10	10	102	102
5		7Д	10	10	102	102
6		7Е	10	10	102	102
7	8-Р АНГИ	8В	10	10	102	102
8		8Д	10	10	102	102
	НИЙТ	8	88	88	879	879

3. Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт
  - Англи хэлний түвшин ахисан
  - Солонгос хэл сурч байна
  - Шатар тоглож, дасгал хийсэн
  - Монгол бичгийн уран бичлэгийг сонирхон судалж байгаа
4. Судлагдахууны хөтөлбөрийн үр дүн
  - Англи хэлний хичээлийн хөтөлбөрийг төлөвлөж хичээлээ түүнийхээ дагуу зохион байгуулж байна
5. Журнал бичилт
  - Журналаа дүрэм журмын дагуу бичиж, 7 хоног бүр сургалтын менежерт хураалган шалгуулдаг
6. Хичээлд ордог сурагчдын хүртээмж
  - Хичээлээ хүртээмжтэй явуулахын тулд 7 хоногийн 3 оролтныхоо 1 цагийг ярианы болон багийн бэтээлийн хичээл болгон зохион байгуулдаг

- Сурагчид харилцан яриа цээжлэн, түүнтэй адил харилцан яриа зохиож найзууддаа ярьж өгдөг
- 7. Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт
  - Багшийн хөгжлийн дэвтрийг тогтмол цаг тухай бүрт нь хөтөлдөг
  - Цэнэглэх цаг болон, жижүүр багшийн хуудсаа багш хөгжлийн дэвтэртээ нааж тэмдэглэдэг
- 8. Хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн бүтээлч ажил
  - Шинэ үгийн толь бичгийн дэвтэр өөрсдөөр нь хөтлүүлдэг
  - Хичээл болгоны эхний 5 минутын шинэ үгийн шалгалт амаар болон бичгээр
  - 7 хоногт 1 удаа багийн бүтээлч ажил
  - Ярианы цаг
  - Сонсголын цаг
- 9. Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа байдал
  - 5в ангийн сурлагаар хоцрогдсон сурагчидтай ганцаарчлан ажилладаг
  - 7-р ангийн хоцрогдолтой сурагчдад Багш Эцэг эхийн харилцааны дэвтрийг 2 дахь жилдээ хөтлөн явуулж байна

### III. **Авьяасыг нээн судлах хөгжүүлэх**

1. Сонирхлын судалгаа
  - Хэлний чадваруудын сонирхлын судалгаа
  - Эцэг эхийн оролцооны талаарх судалгаа
2. Уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх
  - Сурагчдаар сард нэг удаа дуртай англи номыг нь уншуулж ярилцдаг
  - Уншсан номын тэмдэглэлийн дэвтэр хөтлүүлж хэвшсэн
3. Бүтээлийн үзэсгэлэн гаргасан байдал
  - Улирал бүр сурагчдын бүтээлийн үзэсгэлэнг гаргадаг
  - 5р анги цэвэр бичиг, зохион бичлэг
  - 7р анги тодорхой сэдвийн хүрээнд бүтээл хийж түүнийх нь тухай яриулдаг
4. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлсэн байдал  
Олимпиад уралдаан тэмцээн /Улс нийслэл, дүүрэг, сургууль/  
Үндсэн хэлний бөгөөд стандарт ангийн сурагчдыг олимпиадад бэлтгэн амжилт үзүүлсэн. Үүнд

#### Сурагчдын гаргасан амжилт

- 5в ангийн сурагч А.Энхжин Шинэ зуун билэг сургуулийн нэрэмжит олимпиадад 3-р байр
  - 5в ангийн сурагч Хаш Шинэ зуун билэг сургуулийн нэрэмжит Нийслэлийн Англи хэлний олимпиадад Тусгай байр
  - Сургуулийн Гүнзгий ангийн сурагчдын дундах олимпиадад 5в ангийн Сурагч Энхжин 3-р байр хүрэл медаль
  - 5в ангийн 5 сурагчийг сурагчдыг Олон улсын НIPPO олимпиадад бэлтгэж байна.
  - Нийслэлийн сурагчдын Илтгэлийн тэмцээнд уралдаанд Илтгэх урлаг мэтгэлцээний ЛОГОС клубын сурагч Мишээл тэргүүн байр, Мөнхсаруул тусгай байр
  - Энэтхэг улсаас зохион байгуулдаг Олон улсын түвшний олимпиадад 7-р ангийн 3 сурагч 5-р ангийн 1 сурагч амжилттай оролцсон
5. Бүтээлч ажил
    - Сурагчдыг номын тэмдэглэлийн дэвтэртэй болгосон

- Сурагчдын ярианы цагийг гаргаж ярианы чадварын хөгжүүлэхэд анхаарч байна
  - Сурагч бүр шинэ үгийн хувийн толь бичгийг өөрсдөөр хийлгэн ашиглуулдаг
  - Эцэг эх сурагчдын харилцааны дэвтрийг нээн эцэг эхтэй харилцдаг
6. Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж анги нийтээрээ хөгжсөн байдал
- 7 хоногт 1 удаа багийн хичээл зохион байгуулж ярианы чадварын сайжруулдаг
7. Багш ажлын байран дээрээ хөгжсөн байдал
- Мэргэжлийн зэргээ ахиулж магистрт суралцаж байна
  - Гадаад хэлний мэдлэгээ ахиулахын тулд суралцдаг
  - Англиас гадна өөр хэл бие даан суралцаж эхэлэ байгаа
  - Илтгэлийн уралдаанд идэвхитэй оролцож мэргэжлийн мэдлэг ойлголтоо дээшлүүлдэг

#### **IV. Боловсролын сэтгэл ханамж**

1. Цаг ашиглалт
  - Хувийн цаг ашиглалт, хувиар гарган ажилладаг
  - Хичээл эхлэхийн өмнө хичээлээ бэлтгэдэг
  - Цахим хичээл бэлтгэн хичээлээ зохион байгуулдаг
2. Сэтгэл ханамжийн судалгааны
  - Эцэг эхээс “Эцэг эхийн оролцооны талаарх ” судалгаа авсан
  -
3. Хичээлийн цагийн хариуцлага-40 минут
  - Хичээлийн 40 минутыг хариуцлагатай зохион байгуулдаг
4. Багшийн ёс зүй, хууль эрх зүйн биелэлт
  -
5. Багшийн хичээлийн бэлтгэл
  - Хичээлээ цахим хэлбэрээр бэлтгэдэг
6. Хоцрогч таслагч сурагчидтай ажилласан байдал хүрсэн үр дүн
  - Хичээл цагаар тасалдаг сурагчдын эцэг эхтэй уулзан шаардлага тавьж эцэг эх харилцааны дэвтрийг ажиллуулан хамтран ажилладаг
  - Хоцорсон хичээлийг нь нөхөхийн тулд өглөө хичээлийнх нь өмнө ирүүлж давтлага хичээл хийж нөхсөн
7. Багш сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлж байгаа байдал
  - ээлжит болон нэгж хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөг цаг тухайл нь хийж батлуулдаг
  - Журналыг сургалтын менежерээсээ зөвлөгөө авч зохих журмын дагуу,
8. Сургалтын техник хэрэгслийг ашигласан байдал
  - Хичээлийн 3 уддаа ороход 2 удаа цахим хичээл явуулдаг
9. Сурагчдын хөгжил төлөвшил эрсдэлийн судалгааны сан бүрдэлт
  - Хичээлийн явцад эрсдэлтэй зүйл ажиглагдвал тухайн ангийн багшид хандан шийддэг

#### **V. Эрүүл мэнд**

1. Мэндлэх хүндлэх –Зөв боловсон харилцаа
  - Хичээл болгоныг мэндлэн эхлүүлдэг
  -
2. Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал

- Хичээлийн явцад сурагч бэртэж гэмтэх тохиолдолд анхан шатны тусламж үзүүлж, шаардлагатай бол эмчид ханддаг
- 3. Эрүүл мэндийн сургалт зохион байгуулж гарсан үр дүн
  - Хичээлтэйгээ уялдуулан эрүүл мэндийн зөвлөгөө өгдөг
- 4. Анги танхимын цэвэр эмх цэгцтэй байдалд сургаж хэвшүүлсэн байдал
  - Хичээлийн эхэнд ангийн ариун цэвэрт анхаарч, хогийг нь авхуулан хичээлээ эхэлдэг
- 5. Эрүүл орчинд байхын ач тусын талаар ойлголт өгч хэвшил болохуйц ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байдал
  - 5р ангийн эрүүл орчны тухай дуу зааж, кино үзүүлэн утгыг нь ярилцан хичээлээ зохион байгуулсан
  - Үүний дүнд сурагчид хог хаяхаа больсон
- 6. Жижүүр сурагчдын үйл ажиллагаа жигд ажиллагаатай эсэх
  - Жижүүр багш хийхдээ жижүүр ангийн сурагчидтай хамтран зохих шаардлага тавьж оролт, гаралтанд анхаарч ажилладаг
- 7. Анги танхимын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар зөв ойлголт өгч, тэдгээртэй зөв харилцах дадал хэвшилд сургасан байдал
  - Хичээл эхлэхийн өмнө ширээ сандлыг нь тэгшлүүлээд хичээл эхэлдэг
- 8. Эрүүл мэндийн үзлэг, сургалт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж хэрэгжүүлсэн байдал
  - Эрүүл мэндийн мэдлэгийг хичээлээрээ дамжуулан сурагчдад өгдөг
- 9. Ангийн ариун цэвэр эрүүл мэндийн булангийн хэрэгжилт
  - Хичээл болгоны эхэнд ангийн ариун цэвэрт анхааран, ширээ сандлыг нь тэгшлүүлэн, хогийг нь авхуулаад эхлэдэг
- 10. Эрүүл шүд-Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн ажил
  - 7-р ангийн сурагчдыг шүд амны эрүүл ахуйтай холбоотой хичээлийг зохион байгуулсан

### Дүгнэлт

Энэ хичээлийн жилд нийт 194 сурагчдын дүрмийн мэдлэг, сонсох чадвар, унших болон ярих чадваруудыг сайжруулах тал дээр анхааран ажиллалаа. Энэ хүрээнд 7 хоногт 3 удаа ордог хоёрдогч хэлний ангийханд 1 удаагийн оролтыг нь сонсголын болон ярианы хичээл зохион байгууллаа. Мөн багийн хичээлийг бас 14 хоногт 1 удаа орсон. Ингэхэд сурагчдын идэвхи оролцоо сайжирч байгаа нь ажиглагдлаа. Харин гүнзгийрүүлсэн сургалттай буюу 7 хоногт 5 цаг ордог 5в ангийн сурагчдын хувьд жүжигчилсэн тоглолт тоглуулж, дуу шүлэг заасан.

Үйл ажиллагааг төлөвлөн амжилттай зохион явуулж сурагчдыг сургалтын явцад төлөвшүүлэх, зөв харилцаа тэр тусмаа бие биенээ хүндэтгэн сонсох харилцааны чадварт сургах, үнэлгээний өөрийн болон бусдыг шударгаар үнэлэх арга барилд сургах мөн сурагчид санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж, илтгэх чадвартай болгоход дэмжин ажилласан бөгөөд эдгээр чадварууд, арга барилыг тухай бүр ажиглан тэмдэглэхийг зорин ажиллаа. Мөн гадаад хэлний хичээлээр эзэмших чадваруудыг жигд хөгжүүлэх дунд ангийн сурагчдын хувьд сонсох ярих чадварыг түлхүү хөгжүүлэхийн тулд дуу шүлэг, жүжигчилсэн тоглолт, илтгэх, ном уншин тэмдэглэл хөтлөх харин ахлах ангийн сурагчдын хувьд

сонирхолтой сэдвээр илтгэх, хичээл бэлдэн заах зэрэг сонирхолтой аргуудыг хэрэглэн сургалтын үйл ажиллагааг явуулав.


Цаашид төлөвлөсөн төлөвшил чадваруудыг хөгжүүлэх ажлаа нарийн тэмдэглэл хөтлөн сурагч бүрийн ахицыг тооцон ажиллах хэрэгтэй байна. Мөн мэдлэг чадварын сорил шалгалтын дүнгийн анализаас харахад сурагчид хэлзүйн дүрэм бөгөөд зохион бичих чадварын алдаа их байгааг анхаарч одоо болон өнгөрсөн болон одоо цагуудын ялгааг бүрэн таниулах нь зүйтэй байна. Мөн стандарт хэрэгжилтийн хувьд ангийн сурагчдын түвшнээс доогуур сурч байгаа сурагчидтай хамтран ажиллаж стандартын хоцрогдолгүй болгоход анхаарч ажиллах болно.

Тайлан бичсэн: С.Мягмарсүрэн

## Хавсралт



Нийслэлийн багш нарт Илтгэл  
хэлэлцүүлэв



Багш хөгжлийн дэвтэр хөтлөлт



Ярианы хичээлийн үйл явц

